БУЛГАН АЙМГИЙН
САНХҮҮГИЙН ХЯНАЛТ
ДОТООД АУДИТЫН АЛБА

# САНХҮҮГИЙН ХЯНАЛТ ДОТООД АУДИТЫН АЛБАНЫ ЗОРИЛТ АРГА ХЭМЖЭЭНИЙ ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАНГИЙН ТАНИЛЦУУЛГА

## НЭГ. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ЗОРИЛГО.

Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх “Шинэ хөгжлийн зам” хөтөлбөрийн байгууллагад хамаарах арга хэмжээний 2023 оны хэрэгжилтийг тухайн онд тавьсан зорилт, хүрэх түвшин, шалгуур үзүүлэлтүүдтэй харьцуулан тооцож, үр дүнг үнэлэн дүгнэлт өгч, зөвлөмж боловсруулж, удирдлагыг үнэн бодит мэдээллэр хангах, төлөвлөсөн зорилтыг бүрэн биелүүлэхэд дэмжлэг үзүүлэх, үйл ажиллагааны гүйцэтгэл, үр дүн, үр нөлөөг нэмэгдүүлэх, хэрэгжилт хариуцлагыг сайжруулахад хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго оршино.

## ХОЁР. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНДЭСЛЭЛ, ҮНЭЛГЭЭНИЙ АРГА ЗҮЙ.

Төлөвлөгөөнд тусгагдсан зорилт, арга хэмжээний хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ үнэлгээ хийхдээ аймгийн Засаг даргын 2021 оны А/207 дугаар захирамжаар баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх журам”-ыг удирдлага болгов. Ингэхдээ аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх “Шинэ хөгжлийн зам” хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан зорилт арга хэмжээний хэрэгжилтийн 2023 оны тайланг судлах, гүйцэтгэлийн мэдээлэлтэй тулгаж шалгах, мэргэжилтнүүдтэй уулзаж ярилцах, тодруулга авах арга хэлбэрээр хяналт-шинжилгээ, үнэлгээг гүйцэтгэв. хийхдээ Засгийн газрын 2020 оны 206 дүгээр тогтоол, Булган аймгийн Засаг даргын 2021 оны А/207 дугаар захирамжаар баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх журам”-ыг үндэслэв.

Төлөвлөсөн арга хэмжээ бүрийн тухайн жилд хэрэгжүүлсэн ажлын бодит үр дүнг хүрэх түвшинтэй харьцуулан биелэлтийг хувиар тодорхойлж, зорилтын хэрэгжилтийг дараах ангилалд шилжүүлэн тооцлоо. Үүнд: “үр дүнтэй”-100.0%, “тодорхой үр дүнд хүрсэн”-70,0-99,0%, “эрчимжүүлэх шаардлагатай”-31,0-69,0 %, “үр дүнгүй”-0-30,0 % үнэлгээг гаргалаа.

## ГУРАВ. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ҮР ДҮН.

Санхүүгийн хяналт дотоод аудитын албанд хамаарах 12 зорилтын 2024 онд хэрэгжүүлэхээр тодорхойлсон хүрэх түвшин, үр дүнгийн үзүүлэлтэд тусгагдсанаар жилд 2 удаа гаргахаар заасан 12 зорилтын дундаж үнэлгээ 97,2 хувьтай байна.

Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний 5 зорилт 48 арга хэмжээнээс 100 хувьтай биелсэн арга хэмжээ-43, 90 хувьтай биелсэн арга хэмжээ-1, 80 хувьтай биелсэн арга хэмжээ-1, 31 хувьтай биелсэн арга хэмжээ-1 /Акт албан шаардлага барагдуулалтын түвшинд дотоод хяналт шалгалт хийж өмнөх оны актын төлбөрийн үлдэгдлийг 50 хувиар бууралахаар төлөвлөсөн боловч, өмнөх оны актын төлбөрийн үлдэгдэл 54,295.0 мянган төгрөгийн төлбөрөөс 5 актын төлбөр 16,958,0 мянган төгрөгийн төлбөрийг барагдуулж үлдэгдэл 37,337.2 мянган төгрөг байна. Өмнөх оны актын барагдуулалт хувь 31,2 хувь байна/ буюу 45 арга хэмжээ “үр дүнтэй”, 1 арга хэмжээ “эрчимжүүлэх шаардлагатай”, 2 арга хэмжээ хамааралгүй буюу үнэлэх боломжгүй нийтдээ биелэлтийн дундаж үнэлгээ 98,3 хувьтай байна.

Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн биелэлтийн тайлан

Хүний нөөцийг хөгжүүлэх идэвхжүүлэх хөтөлбөрийн хүрээнд 13 удаагийн сургалтад албан хаагчид 100 хувь хамрагдсан, Сангийн яамнаас зохион байгуулсан “Дотоод

аудиторуудын форум” сэдэвт сургалтад 2 албан хаагч оролцсон. Сургалттай холбоотой албан томилолтын зардалд 2,656.0 мянган төгрөгийг зарцуулсан, цалин шагнал урамшуулалд нийт төсвийн 85,1 хувь буюу 261,311.0 мянган төгрөгийг зарцуулсан, нэг ажилтанд дундажаар 874.6 мянган төгрөгийн хоолны хөнгөлөлт олгосон, галлагаатай байшинд амьдардаг 4 албан хаагчид тус бүр 300,0 мянган төгрөг нийт 1200,0 мянган төгрөгийн түлшний хөнгөлөлт, албан хаагчдын 1, 2 дугаар улирлын үр дүнгийн урамшуулал 7 албан хаагчид 7,491.0 мянган төгрөгийг тус тус олгосон.

БОДЛОГЫН БАРИМТ БИЧГИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЛААР:

Удирдлага, зохион байгуулалт, хяналт шалгалтын чиглэлээр:

Хөтөлбөрийн хэрэгжилтийг хангуулах хүрээнд Төсвийн Ерөнхийлөн захирагчаар 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө, хяналт шалгалтын графикаа батлуулан ажиллаж байна. Санхүүгийн хяналт аудитын алба нь Монгол улсын засгийн газрын 2014 оны 327-р тогтоол, аймгийн Засаг даргын 2015 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн Б/12 тоот захирамжаар байгуулагдсан. Байгууллагын нийт батлагдсан орно тоог 9 байхаар сангийн яамнаас баталсан боловч одоогоор 8 орон тоотойгоор, нягтлан бодогчийн орон тоо дутуу ажиллаж байна.

Монгол улсын Засгийн газрын 2021 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн 377 дугаар тогтоолоор Санхүүгийн хяналт, аудитын алба нэршлийг Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба болгон өөрчилсөн.

Тайлант онд 16 сумын хоршоог хөгжүүлэх сангийн 2023 оны санхүү үйл ажиллагаанд дотоод аудит, Номын сан, Музей, Булган соёлын төв, Соёл урлагийн газар, Спортын дунд сургууль, Хутаг-Өндөр, Тэшиг, Орхон, Бугат, Сайхан сумдын төсөвт байгууллагууд, байгаль хамгаалах сан, Хутаг-Өндөр сумын сум дундын ойн анги, Тэшиг, Бугат, Хялганат тосгоны ойн ангийн 2023 оны санхүү үйл ажиллагаанд төлөвлөгөөт санхүүгийн хяналт шалгалтыг, Булган аймгийн Хөгжимт жүжгийн театрын 2023-2024 оны 1 дүгээр улирлын санхүүгийн үйл ажиллагаанд, Зам тээврийн хөгжлийн яамнаас ирүүлсэн хүсэлтийн дагуу Булган АЗЗА ТӨХК-ийн 2023 оны санхүүгийн үйл ажиллагаанд, Сайхан сумын Засаг даргын тамгын газрын 2022 оны санхүү үйл ажиллагаанд, хялганат тосгоны соёлын төвийн 2022 оны санхүү үйл ажиллагаанд, Хишиг-Өндөр сумын ИТХ-ын 2023 оны санхүү үйл ажиллагаанд, Бугат сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүү үйл ажиллагаанд, Орхон сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны санхүү үйл ажиллагаанд, Хишиг-Өндөр суманд 2024 онд аймгийн онцгой комиссоос олгосон тэжээлийг сумын малчин иргэдэд олгосон зарцуулалтын байдалд төлөвлөгөөт бус хяналт шалгалтыг хийсэн.

Санхүүгийн хяналт шалгалтаар улсын ахлах байцаагчийн 57 актаар 48,175.1 мянган төгрөгийн төлбөр тогтоож, 128,019.6 мянган төгрөгийн зөрчилд улсын байцаагчийн 33 албан шаардлага хүргүүлсэн байна. Тайлант онд тавигдсан актын төлбөрөөс 37 байгууллагын 17,801.0 мянган төгрөгийн актын төлбөрийг, өмнөх оны актын төлбөрөөс 16,958.0 мянган төгрөгийн төлбөрийн актыг барагдуулж, 128,019.6 мянган төгрөгийн зөрчилд улсын байцаагчийн 33 албан шаардлагаас 18 байгууллагын 60,075.3 мянган төгрөгийн зөрчлийг арилгуулж, 3 байгууллагын 68,164.3 мянган төгрөгийн албан шаардлагын үлдэгдэл байна. /Тоон тайланд зөрчлийн ангилал, албан шаардлага, актын төлбөрийн талаар тодорхой байгаа тул дурдаагүй/

Шилэн дансны тухай хууль, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолын хэрэгжилтийг хангах зорилгоор Төсвийн Ерөнхийлөн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудад тухай бүр, сар, улирал бүр хяналт тавьж илэрсэн зөрчлийг цаг тухай бүр нь засуулан мэдээ тайлан нэгтгэн холбогдох газруудад хүргүүлэн дотоод хяналтыг хэрэгжүүлэн ажилласны дүнд шилэн дансны нэгдсэн системд бүртгэлтэй байгууллагын мэдээлсэн байдал 99,5 хувьтай тайлагнасан. Шилэн дансны хуулийн хэрэгжилт, илэрсэн зөрчлийн талаарх мэдээллийг шалгагдсан бүх сум байгууллагад хийсэн. Хутаг-Өндөр, Тэшиг сумдын ИТХ-тай албан байгуулллагын дарга албан хаагчид болон иргэдэд “Шилэн дансны тухай хууль”-ийн хэрэгжилтийн талаар мэдээлэл өгч, сургалт зохион байгуулсан.

Тоон тайлан:

| д/д | Аймгийн нэр /Байгууллагын нэр/ | АКТ | | | Үүнээс | | | | Торгосон торгууль | Шийдвэрлэсэн | | | Үүнээс | | | | Барагдсан торгууль | Үлдэгдэл | | | Үүнээс | | | | Торгуулийн үлдэгдэл |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | Өмнөх онд Актаар тогтоосон төлбөр зөрчлийн үлдэгдлийн дүн | Тайлант онд Актаар тогтоосон төлбөр зөрчлийн дүн | НИЙТ ДҮН | Улсын Төсөвт | Тухайн байгууллагад | Орон нутгийн төсөвт | Хуулийн байгууллагад шилжүүлсэн | | Өмнөх оны үлдэгдлээс | Тайлант онд тогтоосон актны дүнгээс | НИЙТ ДҮН | Улсын Төсөвт | Тухайн байгууллагад | Орон нутгийн төсөвт | Хуулийн байгууллагад шилжүүлсэн | | Өмнөх оны үлдэгдэл | Тайлант онд тогтоосон актын үлдэгдэл | НИЙТ ҮЛДЭГДЭЛ | Улсын Төсөвт | Тухайн байгууллагад | Орон нутгийн төсөвт | Хуулийн байгууллагад шийдвэрлэрүүлэхээр ий | |
| 1 | Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв | 6,599.1 | | 6,599.1 | | 1,038.8 | 5,560.3 | | | | | | | | | | | 6,599.1 | 0.0 | 6,599.1 | 0.0 | 1,038.8 | 5,560.3 | 0.0 | 0.0 |
| 2 | Аймгийн нөөц | 300.0 | | 300.0 | | | 300.0 | | | | | | | | | | | 300.0 | 0.0 | 300.0 | 0.0 | 0.0 | 300.0 | 0.0 | 0.0 |
| 3 | Баян-Агт сум ЭМТөв | 10,768.0 | | 10,768.0 | | 55.4 | 0.0 | 10,712.6 | | | | | | | | | | 10,768.0 | | 10,768.0 | | 55.4 | | 10,712.6 | |
| 4 | Аймгийн Нөөцийн газар | 1,486.5 | | 1,486.5 | | | 1,486.5 | | | | | | | | | | | 1,486.5 | | 1,486.5 | | 0.0 | | 1,486.5 | |
| 5 | Хангал сумын цэцэрлэг | 27.4 | | 27.4 | | | 27.4 | | | 27.4 | | 27.4 | | | 27.4 | | | 0.0 | 0.0 | 0.0 | | 0.0 | 0.0 | 0.0 | |
| 6 | Нийгмийн даатгалын хэлтэс /Нийгмийн даатгалын сан/ | 6,395.2 | - | 6,395.2 | | 6,395.2 | | | | 3,027.8 | | 3,027.8 | | 3,027.8 | | | | 3,367.4 | - | 3,367.4 | | 3,367.4 | 0.0 | 0.0 | |
| 7 | | 84.0 | - | 84.0 | | 84.0 | | | | 84.0 | | 84.0 | | 84.0 | | | | 0.0 | - | 0.0 | | 0.0 | 0.0 | 0.0 | |
| 8 | Бүрэгхангай сумын ЭМТ | 134.2 | - | 134.2 | | | 134.2 | | | 134.2 | | 134.2 | | | 134.2 | | | 0.0 | - | 0.0 | | 0.0 | 0.0 | 0.0 | |
| 9 | | 190.5 | - | 190.5 | | | 190.5 | | | 190.5 | | 190.5 | | | 190.5 | | | 0.0 | - | 0.0 | | | 0.0 | | |
| 10 | Орхон эрүүл мэндийн төв | 245.6 | | 245.6 | | | | 245.6 | | | | | | | | | | 245.6 | | 245.6 | - | - | | 245.6 | - |
| 11 | Орхон эрүүл мэндийн төв | 688.5 | | 688.5 | | | | 688.5 | | | | | | | | | | 688.5 | | 688.5 | | | | 688.5 | |
| 12 | Орхон эрүүл мэндийн төв | 84.0 | | 84.0 | | | | 84.0 | | | | | | | | | | 84.0 | | 84.0 | | | | 84.0 | |
| 13 | Орхон эрүүл мэндийн төв | 274.0 | | 274.0 | | | | 274.0 | | | | | | | | | | 274.0 | | 274.0 | | | | 274.0 | |
| 14 | НДХ | 1,400.0 | - | 1,400.0 | | 1,400.0 | | | | 571.5 | - | 571.5 | | 571.5 | | | | 828.5 | - | 828.5 | - | 828.5 | - | | |
| 15 | Тэшиг Эрүүл мэндийн төв | 5,246.5 | | 5,246.5 | | | 5,246.5 | | | | | | | | | | | 5,246.5 | | 5,246.5 | | | 5,246.5 | | |
| 16 | Газрын харилцаа барилга хот байгуулалтын газар | 6,522.7 | - | 6,522.7 | | | 6,522.7 | | | | | | | | | | | 6,522.7 | | 6,522.7 | | | 6,522.7 | | |
| 17 | Бугат ЗДТГ | 300.0 | | 300.0 | | | 300.0 | | | | | | | | | | | 300.0 | | 300.0 | | | 300.0 | | |
| 18 | Тэшиг сумын Засаг дарга | 10,137.4 | - | 10,137.4 | | 10,137.4 | | | | 10,137.4 | | 10,137.4 | | 10,137.4 | | | | - | | 0.0 | | - | | | |
| 19 | Сайхан сумын ЗДТГ | 1,925.8 | | 1,925.8 | | | 1,925.8 | | | 1,925.8 | | 1,925.8 | | | 1,925.8 | | | | | 0.0 | | | | | |
| 20 | Сайхан сумын ЗДТГ | 408.8 | | 408.8 | | | 408.8 | | | 408.8 | | 408.8 | | | 408.8 | | | | | 0.0 | | | | | |
| 21 | Тэшиг ЗДТГ | 626.2 | | 626.2 | | | 626.2 | - | | | | | | | | | | 626.2 | | 626.2 | | | 626.2 | | |
| 22 | Хангал сумын ЗДТГ | 268.3 | - | 268.3 | | - | 268.3 | | | 268.3 | - | 268.3 | | | 268.3 | | | - | | 0.0 | | | - | | |
| 23 | Баяннуур сум ЗДТГ | 89.2 | - | 89.2 | | | 89.2 | | | 89.2 | - | 89.2 | | | 89.2 | | | - | | 0.0 | | | - | | |
| 24 | Булган сум Ерөнхий боловсролын 1-р сургууль | 93.1 | - | 93.1 | | | 93.1 | | | 93.1 | | 93.1 | | | 93.1 | | | | | 0.0 | | | | | |
| 25 | Хангал сумын Хялганат тосгоны Соёлын төв | | 100.0 | 100.0 | | | 100.0 | | | | | | | | | | | | 100.0 | 100.0 | | | 100.0 | | |
| 26 | Хангал сумын Хялганат тосгоны Соёлын төв | | 383.4 | 383.4 | | | 383.4 | | | | 191.7 | 191.7 | | | 191.7 | | | | 191.7 | 191.7 | | | 191.7 | | |
| 27 | Хангал сумын Хялганат тосгоны Соёлын төв | | 88.0 | 88.0 | | 88.0 | - | | | | - | 0.0 | | | - | | | | 88.0 | 88.0 | | 88.0 | - | | |
| 28 | Хангал сумын Хялганат тосгоны Соёлын төв | | 3,623.1 | 3,623.1 | | | 3,623.1 | | | | | | | | | | | | 3,623.1 | 3,623.1 | | | 3,623.1 | | |
| 29 | Хангал сумын Хялганат тосгоны Соёлын төв | | 918.0 | 918.0 | | | 918.0 | | | | | | | | | | | | 918.0 | 918.0 | | | 918.0 | | |
| 30 | Хангал сумын Хялганат тосгоны Соёлын төв | | 50.0 | 50.0 | | 50.0 | - | | | | - | 0.0 | | | - | | | | 50.0 | 50.0 | | 50.0 | | | |
| 31 | Булган АЗЗА ТӨХК | | 1,181.8 | 1,181.8 | | | 1,181.8 | | | | 1,181.8 | 1,181.8 | | | 1,181.8 | | | | - | 0.0 | | | - | | |
| 32 | Сэлэнгэ сум Хоршоо хөгжүүлэх сан | | 840.1 | 840.1 | | 840.1 | - | | | | 840.1 | 840.1 | | 840.1 | | | | | - | 0.0 | | - | | | |
| 33 | Булган аймгийн Музей | | 305.0 | 305.0 | | | 305.0 | | | | 305.0 | 305.0 | | | 305.0 | | | | - | 0.0 | | | - | | |
| 34 | Хутаг-Өндөр сумын "Илчит хутаг" ОНӨХХК | | 284.0 | 284.0 | | | 284.0 | | | | 284.0 | 284.0 | | | 284.0 | | | | - | 0.0 | | | - | | |
| 35 | Хутаг-Өндөр сумын "Илчит хутаг" ОНӨХХК | | 585.3 | 585.3 | | 585.3 | | | | | | 0.0 | | | | | | | 585.3 | 585.3 | | 585.3 | | | |
| 36 | Тэшиг хоршоо хөгжүүлэх сан | | 410.8 | 410.8 | | | 410.8 | | | | 410.8 | 410.8 | | | 410.8 | | | | - | 0.0 | | | - | | |
| 37 | Хөгжимт жүжгийн театр | | 188.5 | 188.5 | | | 188.5 | | | | 188.5 | 188.5 | | | 188.5 | | | | - | 0.0 | | | - | | |
| 38 | Тэшиг сургууль | | 206.0 | 206.0 | | | 206.0 | | | | 206.0 | 206.0 | | | 206.0 | | | | - | 0.0 | | | - | | |
| 39 | Спортын дунд сургууль | | 250.8 | 250.8 | | | 250.8 | | | | 250.8 | 250.8 | | | 250.8 | | | | - | 0.0 | | | - | | |
| 40 | Орхон Эрүүл мэндийн төв | | 1,604.4 | 1,604.4 | | | 1,604.4 | | | | | 0.0 | | | | | | | 1,604.4 | 1,604.4 | | | 1,604.4 | | |
| 41 | Орхон Эрүүл мэндийн төв | | 445.6 | 445.6 | | | 445.6 | | | | | 0.0 | | | | | | | 445.6 | 445.6 | | | 445.6 | | |
| 42 | Орхон Эрүүл мэндийн төв | | 144.8 | 144.8 | | | 144.8 | | | | | 0.0 | | | | | | | 144.8 | 144.8 | | | 144.8 | | |

| | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 43 | Хөгжимт жүжгийн театр | | 600.0 | 600.0 | | | 600.0 | | | | 600.0 | 600.0 | | | 600.0 | | | | - | 0.0 | | | - | | |
| 44 | Булган сум Хоршоо хөгжүүлэх сан | | 1,241.3 | 1,241.3 | | 1,241.3 | | | | | 1,241.3 | 1,241.3 | | 1,241.3 | | | | | - | 0.0 | | | | | |
| 45 | Хутаг-Өндөр сум ЗДТГ | | 374.6 | 374.6 | | 374.6 | | | | | 374.6 | 374.6 | | 374.6 | | | | | - | 0.0 | | | | | |
| 46 | Хутаг-Өндөр сум ЗДТГ | | 48.5 | 48.5 | | | 48.5 | | | | 48.5 | 48.5 | | | 48.5 | | | | - | 0.0 | | | | | |
| 47 | Хутаг-Өндөр сум ИТХ | | 20.9 | 20.9 | | 20.9 | | | | | 20.9 | 20.9 | | 20.9 | | | | | - | 0.0 | | | | | |
| 48 | Хутаг-Өндөр сум Сум дундын ойн анги | | 276.9 | 276.9 | | | 276.9 | | | | | 0.0 | | | | | | | 276.9 | 276.9 | | | 276.9 | | |
| 49 | Булган аймгийн Соёл урлагийн газар | | 248.1 | 248.1 | | 248.1 | | | | | 248.1 | 248.1 | | 248.1 | | | | | - | 0.0 | | | | | |
| 50 | Булган аймгийн Соёл урлагийн газар | | 744.6 | 744.6 | | | 744.6 | | | | 744.6 | 744.6 | | | 744.6 | | | | - | 0.0 | | | | | |
| 51 | Булган аймгийн Соёл урлагийн газар | | 126.8 | 126.8 | | 126.8 | | | | | 126.8 | 126.8 | | 126.8 | | | | | - | 0.0 | | | | | |
| 52 | Хутаг-Өндөр сумын Эрүүл мэндийн төв | | 169.0 | 169.0 | | 169.0 | | | | | 169.0 | 169.0 | | 169.0 | | | | | - | 0.0 | | | | | |
| 53 | Хутаг-Өндөр сумын Эрүүл мэндийн төв | | 172.0 | 172.0 | | | 172.0 | | | | 172.0 | 172.0 | | | 172.0 | | | | - | 0.0 | | | | | |
| 54 | Хутаг-Өндөр сумын Эрүүл мэндийн төв | | 236.7 | 236.7 | | | 236.7 | | | | 236.7 | 236.7 | | | 236.7 | | | | - | 0.0 | | | | | |
| 55 | Тэшиг сумын Соёлын төв | | 227.6 | 227.6 | | 82.2 | 145.4 | | | | 227.6 | 227.6 | | 82.2 | 145.4 | | | | - | 0.0 | | - | - | | |
| 56 | Хутаг-Өндөр сумын Ерөнхий боловсролын сургууль | | 305.5 | 305.5 | | | 305.5 | | | | 305.5 | 305.5 | | | 305.5 | | | | - | 0.0 | | | - | | |
| 57 | Тэшиг сумын Эрүүл мэндийн төв | | 1,018.4 | 1,018.4 | | | 1,018.4 | | | | 1,018.4 | 1,018.4 | | | 1,018.4 | | | | - | 0.0 | | | - | | |
| 58 | Тэшиг сумын Эрүүл мэндийн төв | | 456.7 | 456.7 | | 456.7 | | | | | 456.7 | 456.7 | | | 456.7 | | | | - | 0.0 | | - | | | |
| 59 | Тэшиг сумын Эрүүл мэндийн төв | | 652.3 | 652.3 | | | 652.3 | | | | 652.3 | 652.3 | | | 652.3 | | | | - | 0.0 | | | - | | |
| 60 | Хутаг-Өндөр сумын Ерөнхий боловсролын сургууль | | 2,282.1 | 2,282.1 | | | 2,282.1 | | | | 1,141.0 | 1,141.0 | | | 1,141.0 | | | | 1,141.1 | 1141.1 | | | 1,141.1 | | |
| 61 | Орхон сумын Соёлын төв | | 351.0 | 351.0 | | | 351.0 | | | | 351.0 | 351.0 | | | 351.0 | | | | - | 0.0 | | | - | | |
| 62 | Орхон сумын цэцэрлэг | | 334.2 | 334.2 | | 133.7 | 200.5 | | | | 133.7 | 133.7 | | 133.7 | | | | | 200.5 | 200.5 | | - | 200.5 | | |
| 63 | Бугат сумын Эрүүл мэндийн төв | | 320.4 | 320.4 | | | 320.4 | | | | 160.4 | 160.4 | | | 160.4 | | | | 160.0 | 160.0 | | | 160.0 | | |
| 64 | Бугат сумын Эрүүл мэндийн төв | | 416.3 | 416.3 | | | 416.3 | | | | | 0.0 | | | | | | | 416.3 | 416.3 | | | 416.3 | | |
| 65 | Сайхан сум Ерөнхий боловсролын сургууль | | 220.0 | 220.0 | | | 220.0 | | | | | 0.0 | | | | | | | 220.0 | 220.0 | | | 220.0 | | |
| 66 | Бугат сум ЕБСургууль | | 201.6 | 201.6 | | | 201.6 | | | | | 0.0 | | | | | | | 201.6 | 201.6 | | | 201.6 | | |
| 67 | Тэшиг сум ЗДТГ | | 128.0 | 128.0 | | | 128.0 | | | | 128.0 | 128.0 | | | 128.0 | | | | | 0.0 | | | | | |
| 68 | Орхон сум ЗДТГ | | 619.0 | 619.0 | | 619 | - | | | | 619.0 | 619.0 | | 619 | - | | | | - | 0.0 | | | - | - | |
| 69 | Орхон сум ИТХ | | 122.7 | 122.7 | | | 122.7 | | | | | 0.0 | | | - | | | | 122.7 | 122.7 | | | 122.7 | | |
| 70 | Хишиг-Өндөр сум ЗДТГ | | 1,334.5 | 1,334.5 | | 1,334.5 | | | | | 1,334.5 | 1,334.5 | | 1,334.5 | | | | | | 0.0 | | | | | |
| 71 | Сайхан сум ЗДТГ | | 132.0 | 132.0 | | | 132.0 | | | | 84.0 | 84.0 | | | 84.0 | | | | 48.0 | 48.0 | | | 48.0 | | |
| 72 | Сайхан сум ЗДТГ | | 260.5 | 260.5 | | 260.5 | | | | | 260.5 | 260.5 | | 260.5 | | | | | - | 0.0 | | - | | | |
| 73 | Орхон сум ЕБС | | 1,254.4 | 1,254.4 | | 1,254.4 | | | | | - | 0.0 | | | | | | | 1,254.4 | 1254.4 | | 1,254.4 | | | |
| 74 | Бугат сумын цэцэрлэг | | 561.3 | 561.3 | | 561.3 | | | | | 561.3 | 561.3 | | 561.3 | | | | | - | 0.0 | | | | | |
| 75 | Бугат сумын цэцэрлэг | | 399.6 | 399.6 | | | 399.6 | | | | 399.6 | 399.6 | | | 399.6 | | | | - | 0.0 | | | | | |
| 76 | Хишиг-Өндөр сум ИТХ | | 2,126.3 | 2,126.3 | | 2,126.3 | | | | | 2,126.3 | 2,126.3 | | 2,126.3 | | | | | - | 0.0 | | | | | |
| 77 | Политехникийн коллеж | | 6,500.0 | 6,500.0 | | 6,500.0 | | | | | | 0.0 | | | | | | | 6,500.0 | 6500.0 | | 6,500.0 | | | |
| 78 | Сайхан сум Соёлын төв | | 9,845.3 | 9,845.3 | | 9,845.3 | | | | | | 0.0 | | | | | | | 9,845.3 | 9845.3 | | 9,845.3 | | | |
| 79 | Сайхан сум Соёлын төв | | 1,059.4 | 1,059.4 | | 491.6 | 567.8 | | | | | 0.0 | | | | | | | 1,059.4 | 1059.4 | | 491.6 | 567.8 | | |
| 80 | Сайхан сум Соёлын төв | | 129.2 | 129.2 | | | 129.2 | | | | | 0.0 | | | | | | | 129.2 | 129.2 | | | 129.2 | | |
| 81 | Сайхан сум Соёлын төв | | 1,047.8 | 1,047.8 | | | 1,047.8 | | | | | 0.0 | | | | | | | 1,047.8 | 1047.8 | | | 1,047.8 | | |
| | **Аймгийн дүн** | **54,295.0** | **48,175.1** | **102,470.1** | **0.0** | **46,520.4** | **43,945.0** | **12,004.7** | **0.0** | **16,958.0** | **17,801.0** | **34,759.0** | **0.0** | **21,959.0** | **12,800.0** | **0.0** | **0.0** | **37,337.0** | **30,374.1** | **67,711.1** | **0.0** | **24,104.7** | **30,115.2** | **13,491.2** | **0.0** |

## *Байгууллагын ил тод байдлын үнэлгээний тайлан*

| № | Шалгуур үзүүлэлт | Хэрэгжилт | Хувь |
|---|---|---|---|
| Нэг. Үйл ажиллагааны ил тод байдал | | | |
| 1. | Эрхэм зорилго, үйл ажиллагааны стратегийн зорилт, зорилго, тэргүүлэх чиглэл болон тэдгээрийн хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, түүний үр дүн, зохион байгуулалтын бүтцийг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх | Цахим хуудсандаа болон мэдээллийн самбартаа санхүүгийн хяналт шалгалтын тайланг сар бүр мэдээлсэн. | 100 |
| 2. | Үйлчилгээ захидал харилцааны асуудал хариуцсан албан хаагчийн эцэг эхийн нэр, өөрийн нэр, албан тушаал, ажиллах журам, харилцах утас, иргэдийг хүлээн авч уулзах цагийн хуваарийг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх | Ажилтнуудын албан тушаал, утасны дугаарыг байгууллагын цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байрлуулан мэдээлсэн. | 100 |
| 3. | Үйл ажиллагаандаа мөрдөж байгаа хууль тогтоомж, дүрэм, журам, зааврыг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх | Байгууллагын санхүүгийн мэдээллийн самбарыг шинэчлэн байгууллагын үйл ажиллагаа, мөрдөгдөж байгаа хууль, дүрэм журам, тушаал шийдвэрийг мэдээллэсэн, байгууллагын вэб хуудсанд хяналт шалгалтын мэдээллийг тухай бүр нь мэдээлж байна. | 100 |
| ***Хэсгийн дундаж хувь*** | | | ***100*** |
| **Хоёр. Хүний нөөцийн ил тод байдал** | | | |
| 1. | Сул орон тооны зарыг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх, энэ тухай олон нийтийн мэдээллийн хэрэгслээр зарлах | Төрийн бодлогын залгамж чанарыг хадгалах, тогтвор суурьшилтай ажиллуулж, төрийн мэргэшсэн албыг бэхжүүлэх зорилгоор Төрийн албаны тухай хууль, хуулийг дагалдан гарсан дүрэм, журмын дагуу одоо ажиллаж байгаа албан хаагчдын мэдлэг чадварыг дээшлүүлэх, сул орон тоо гарсан үед нөөцөд байгаа төрийн албан хаагчдаас нөхөх бодлого, чиглэлийг баримтлан ажиллаж байна. Тайлант онд 1 сул орон тоо гарсаныг Төрийн албаны тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 1 дэх заалт болон Төрийн албаны зөвлөлийн 2023 оны 25 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн албаны шалгалт өгөх болзол болон шатлан дэвшүүлэх, сонгон шалгаруулах журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.2-т заалтуудыг үндэслэн төрийн албан хаагчийн өөрийн нь гаргасан өргөдлийн дагуу Нийгмийн даатгалын хэлтсээс шилжүүлэн авсан. | 100 |
| 2. | Албан хаагчийн ёс зүйн дүрмийг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх | Төрийн албан хаагчийн ёс зүйн дүрмийг цахим хуудас болон мэдээллийн самбартаа мэдээлж, мэдээллийн самбарт мэдээллэх мэдээллийг тухай бүрт нь шинэчилж байна. | 100 |
| 3. | Хүний нөөцийн стратеги, түүний хэрэгжилтийг хянаж, үнэлэх журмыг цахим хуудсандаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх | Төрийн бодлогын залгамж чанарыг хадгалах, тогтвор суурьшилтай ажиллуулж, төрийн мэргэшсэн албыг бэхжүүлэх зорилгоор Төрийн албаны тухай хууль, хуулийг дагалдан гарсан дүрэм, журмын дагуу одоо ажиллаж байгаа албан хаагчдын мэдлэг чадварыг дээшлүүлсэн. | 100 |
| 4. | Хүний нөөцийн удирдлагын ил тод байдлыг хангах чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаар цахим хуудсандаа ойлгомжтой байдлаар байрлуулан мэдээлж байх | Хүний нөөцийн удирдлагын ил тод байдлыг хангах чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаар цахим хуудсанд ойлгомжтой байдлаар байршуулан баяжилтыг тухай бүр хийж байна | 100 |
| 5. | Албан хаагчдын ажлын гүйцэтгэлийг үнэн зөв шударга болгох чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаар цахим хуудсандаа ойлгомжтой байдлаар байрлуулан мэдээлж байх | Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчдын ажлын үр дүнг хагас жил, жилийн эцсийн байдлаар үнэлж, албан хаагчдад 20-80 хувиар үнэлэн 7,491.0 мянган төгрөгийн урамшуулал олгосон, албан хаагчдын эрүүл мэндийг хамгаалах ажлын хүрээнд Монгол улсын Ерөнхийлөгчийн санаачлагаар хэрэгжүүлж буй ’Эрүүл монгол хүн’’ үндэсний хөдөлгөөн ‘‘илүүдэл жингүй эртэч монгол’’-‘’дасгал хөдөлгөөнд цаг гаргая’’ арга хэмжээний өглөөний дасгалд, "Эерэг хандлага Эрүүл нийгэм" аянд нэгдэж дасгал хөдөлгөөнд бүрэн хамрагдсан. | 100 |
| **Хэсгийн дундаж хувь** | | | **100** |
| **Хэрэгжилтийн дундаж хувь** | | | **100** |

***Шилэн дансны хөтлөлтийн үнэлгээний тайлан***

Шилэн дансны тухай хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ заасны дагуу шилэн дансны нэгдсэн сайтад 163 мэдээлэл оруулахаас 163 мэдээллийг хугацаа хоцроолгүй бүрэн мэдээлж, шилэн дансны вэб сайтын тайланг байгууллагын админ эрхээр илгээсэн.

**Төсөв гүйцэтгэлд цэсэнд мэдээлсэн байдал**

**Булган аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба**

**И-мэйл:** sankhuu_audit_bu@yahoo.com
**Ажлын утас:** 70342244

**Шуудангийн хаяг:** ....
**Сошиал хаяг:**

Дэлгэрэнгүй мэдээлэл | Салбар байгууллагууд

Төсвийн байгууллага

Төсөв, гүйцэтгэл | Хөрөнгө оруулалт, тендер, худалдан авалт | Бусад

Тайлант он: 2024

ⓘ Тэмдэглэгээний тайлба

| № | Тайлангийн нэр | Мэдээллийн төрөл | Мэдээлэл оруулах хугацаа | Заавал эсэх | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 | 10 | 11 | 12 |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | Хайлт хийх | Хайлт хийх | Хайлт хийх | | | | | | | | | | | | | |
| | **Сар бүр** | | | | | | | | | | | | | | | |
| 1 | Төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбарын хамт-эдийн засгийн ангилал | Гүйцэтгэл | дараа сарын 8-ны дотор | * | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ⊖ |
| 2 | Төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл - Хөтөлбөр, зориулалт | Гүйцэтгэл | дараа сарын 8-ны дотор | * | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ⊖ |
| | **Хагас жил бүр** | | | | | | | | | | | | | | | |
| 3 | Санхүүгийн тайлан | Гүйцэтгэл | хагас жилийн тайланг жил бүрийн 8 дугаар сарын 15-ны дотор | * | | | | | | ✓ | | | | | | |
| 4 | Хандив, тусламжийн орлого | Гүйцэтгэл | хагас жилийн тайланг жил бүрийн 8 дугаар сарын 15-ны дотор | * | | | | | | ✓⊘ | | | | | | |
| 5 | Хандив, тусламжийн зарцуулалтын тайлан | Гүйцэтгэл | хагас жилийн тайланг жил бүрийн 8 дугаар сарын 15-ны дотор | * | | | | | | ✓⊘ | | | | | | |

| | | | | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 6 | Өмнөх оны төсвийн зарлагын хэмнэлт, туслах үйл ажиллагааны орлогоос давсан хэсгийг урамшуулалд зарцуулсан тайлан | Гүйцэтгэл | хагас жилийн тайланг жил бүрийн 8 дугаар сарын 15-ны дотор | * | | | | | | ✓⊘ | | | | | | |
| | **Жил бүр** | | | | | | | | | | | | | | | |
| 7 | Санхүүгийн тайлан | Гүйцэтгэл | жилийн тайланг дараа оны 4 дүгээр сарын 25-ны дотор | * | | | | | | | | | | | | ⊖ |
| 8 | Байгууллагын батлагдсан төсөв | Төлөвлөгөө | жил бүрийн 1 дүгээр сарын 10-ны дотор | * | ✓ | | | | | | | | | | | |
| 9 | Дараа жилийн төсвийн төсөл | Төлөвлөгөө | жил бүрийн 9 дүгээр сарын 15-ны дотор | * | | | | | | | | | ✓ | | | |
| 10 | Хандив, тусламжийн зарцуулалтын тайлан | Гүйцэтгэл | жилийн тайланг дараа оны 4 дүгээр сарын 25-ны дотор | * | | | | | | | | | | | | ⊖ |
| 11 | Хандив, тусламжийн орлого | Гүйцэтгэл | жилийн тайланг дараа оны 4 дүгээр сарын 25-ны дотор | * | | | | | | | | | | | | ⊖ |
| 12 | Өмнөх оны төсвийн зарлагын хэмнэлт, туслах үйл ажиллагааны орлогоос давсан хэсгийг урамшуулалд зарцуулсан тайлан | Гүйцэтгэл | жилийн тайланг дараа оны 4 дүгээр сарын 25-ны дотор | * | | | | | | | | | | | | ⊖ |
| 13 | Санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлт | Гүйцэтгэл | дараа оны 4 дүгээр сарын 25-ны дотор | * | | | | | | | | | | | | ⊕ |
| | **Тухай бүр** | | | | | | | | | | | | | | | |
| 14 | Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын мөнгөн гүйлгээ | - | | * | ✓⊘ | ✓⊘ | ✓⊘ | ✓ | ✓⊘ | ✓⊘ | ✓⊘ | ✓⊘ | ✓⊘ | ✓⊘ | ✓⊘ | ⊕ |
| 15 | Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын мөнгөн гүйлгээ | - | | * | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ⊕ |
| 16 | Тухайн жилийн төсөвт орсон нэмэлт, өөрчлөлт | - | 7 хоногийн дотор | * | ✓ | ✓⊘ | ✓⊘ | ✓⊘ | ✓⊘ | ✓ | ✓⊘ | ✓⊘ | ✓ | ✓⊘ | ✓⊘ | ⊕ |

## Хөрөнгө оруулалт, тендэр худалдан авалт цэсэнд мэдээлсэн байдал

Төсөв, гүйцэтгэл | **Хөрөнгө оруулалт, тендер, худалдан авалт** | Бусад

Тайлант он: 2024

ⓘ Тэмдэглэгээний тайлбар

| № | Тайлангийн нэр | Мэдээллийн төрөл | Мэдээлэл оруулах хугацаа | Заавал эсэх | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 | 10 | 11 | 12 |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | Хайлт хийх | Хайлт хийх | Хайлт хийх | | | | | | | | | | | | | |
| | **Сар бүр** | | | | | | | | | | | | | | | |
| 1 | Хөрөнгийн зардал, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний гүйцэтгэл, концессын зүйлийн жагсаалт, гүйцэтгэл | Гүйцэтгэл | дараа сарын 8-ны дотор | * | ✓● | ✓● | ✓● | ✓● | ✓● | ✓● | ✓● | ✓● | ✓● | ✓● | ✓● | ⊖ |
| | **Жил бүр** | | | | | | | | | | | | | | | |
| 2 | Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө | Төлөвлөгөө | жил бүрийн 1 дүгээр сарын 10-ны дотор | * | ✓● | | | | | | | | | | | |
| 3 | Худалдан авах ажиллагааны тайлан | Гүйцэтгэл | дараа оны 1 дүгээр сарын 15-ны дотор | * | | | | | | | | | | | | ⊕ |
| 4 | Хөрөнгийн зардал, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөгөө, концессын зүйлийн жагсаалт | Төлөвлөгөө | жил бүрийн 1 дүгээр сарын 10-ны дотор | * | ✓● | | | | | | | | | | | |
| | **Тухай бүр** | | | | | | | | | | | | | | | |
| 5 | Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг | - | | * | ✓● | ✓● | ✓● | ✓ | ✓● | ✓● | ✓● | ✓● | ✓● | ✓● | ✓● | ⊕ |
| 6 | Хөрөнгийн болон урсгал зардалд тусгагдсан арга хэмжээний тендерийн ерөнхий мэдээлэл | - | | * | ✓● | ✓● | ✓● | ✓● | ✓● | ✓● | ✓● | ✓● | ✓● | ✓● | ✓● | ⊕ |

## Бусад цэсэнд мэдээлсэн байдал

Төсөв, гүйцэтгэл | Хөрөнгө оруулалт, тендер, худалдан авалт | **Бусад**

Тайлант он: 2024

ⓘ Тэмдэглэгээний тайлбар

| № | Тайлангийн нэр | Мэдээллийн төрөл | Мэдээлэл оруулах хугацаа | Заавал эсэх | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 | 10 | 11 | 12 |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | Хайлт хийх | Хайлт хийх | Хайлт хи... | | | | | | | | | | | | | |
| | **Сар бүр** | | | | | | | | | | | | | | | |
| 1 | Байгууллагын батлагдсан орон тоонд орсон өөрчлөлт | Тухай бүрийн төрөл | дараа сарын 8-ны дотор | * | ✓ | ✓ | ✓ | ✓⊘ | ✓⊘ | ✓⊘ | ✓⊘ | ✓⊘ | ✓ | ✓ | ✓ | ⊖ |
| | **Жил бүр** | | | | | | | | | | | | | | | |
| 2 | Аудитын тайлан, дүгнэлт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлан | Гүйцэтгэл | 7 дугаар сарын 1-ний дотор | * | | | | | | | ✓ | | | | | |
| | **Тухай бүр** | | | | | | | | | | | | | | | |
| 3 | Худалдан авах ажиллагаанд хийсэн аудитын тайлан, дүгнэлт болон бусад хяналт шалгалтын дүн | - | | * | ✓⊘ | ✓⊘ | ✓⊘ | ✓⊘ | ✓⊘ | ✓⊘ | ✓⊘ | ✓⊘ | ✓⊘ | ✓⊘ | ✓⊘ | ⊕ |
| 4 | Хавсралт файлууд | - | | * | ✓⊘ | ✓ | ✓⊘ | ✓⊘ | ✓ | ✓⊘ | ✓ | ✓ | ✓⊘ | ✓⊘ | ✓⊘ | ⊕ |
| 5 | Тухайн байгууллагын хууль тогтоомжийн дагуу төвлөрүүлэх төлбөр, хураамж, зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээнд орсон өөрчлөлт | - | | * | ✓⊘ | ✓⊘ | ✓⊘ | ✓⊘ | ✓⊘ | ✓⊘ | ✓⊘ | ✓⊘ | ✓⊘ | ✓⊘ | ✓⊘ | ⊕ |
| 6 | Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8, 9 дүгээр зүйлд заасан мэдэгдэл | - | | * | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓⊘ | ✓ | ✓ | ✓ | ⊕ |
| 7 | Бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр | - | | * | ✓⊘ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ⊕ |

## *Байгууллагын шударга байдлын үнэлгээний тайлан*

| № | Хийж гүйцэтгэх ажил | Хүрэх үр дүн | Биелэлт | Хувь |
|---|---|---|---|---|
| 1. | Нийтийн албанд Нийтийн болон хувийн ашиг сонирхлын зөрчлийг зохицуулах хувийн ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн дагуу хөрөнгө орлогын мэдүүлгийг хуулийн хугацаанд гаргаж холбогдох газарт хүргүүлэх | Хөрөнгө орлогын мэдүүлгийг гаргаж хүргүүлснээр ашиг сонирхлын зөрчил үүсэж болзошгүй нөхцөлөөс урьдчилан сэргийлэх | Монгол Улсын Их Хурлын Хууль зүйн Байнгын хорооны 2012 оны 05 дугаар тогтоолоор батлагдсан " Албан тушаалтны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө орлогын мэдүүлгийг бүртгэх, хянах, хадгалах журам"-ын дагуу 6 албан хаагч 2023 оны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө орлогын мэдүүлгийг шинэчлэн гаргуулж тайланг аймгийн ХЭЗХ-т хүргүүлсэн бөгөөд ажилтан, албан хаагчидтай холбоотой ёс зүйн зөрчлийн болон авлига, хүнд суртлын талаар зөрчил гараагүй болно. | 100 |
| 2. | Албан хаагч, ажилтнуудын ёс зүй, сахилга хариуцлагыг дээшлүүлэх, манлайллыг төлөвшүүлэх арга хэмжээг зохион байгуулах | Санхүүгийн хяналт, шалгалтын улсын байцаагч, аудиторууд нь илрэх ёс зүйн болон ашиг сонирхлын зөрчилгүй ажилласан байх. | Санхүүгийн хяналт, шалгалтын улсын байцаагчид нь хяналт шалгалт, дотоод аудит хийх бүрдээ "Ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдэл"-ийг гаргаж албаны даргаар шийдвэрлүүлж хэвшсэн ба 2024 онд гаргасан мэдэгдэлийг шилэн дансны нэгдсэн сайтад бүрэн мэдээлсэн бөгөөд авлига, ашиг сонирхол болон ёс зүйн зөрчилгүй ажиллаж, ёс зүйн зөрчлөөр арга хэмжээ тооцогдсон албан тушаалтан байхгүй болно. | 100 |
| 3. | Байцаагч нарыг мэргэжил дээшлүүлэх сургалтуудад хамруулах, дотоод аудитын чиглэлээр мэргэшүүлэх. | Мэргэжлийн өндөр ур чадвар бүхий баг бүрдсэн байх | Тайлант онд Булган аймаг дахь Төрийн албаны зөвлөлөөс зохион байгуулсан "Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль" сэдэвт танхимын сургалтад хамрагдсан. Орхон аймагт зохион байгуулсан дотоод аудитын удирдлагын нэгдсэн системд хэрхэн ажиллах талаарх сургалтад хамрагдахын зэрэгцээ тус аймгийн Санхүүгийн хяналт дотоод аудитын албаны нэвтрүүлсэн "Нэгдсэн менежмент тогтолцооны стандарт нэвтрүүлсэн сайн туршлага"-ын талаар мэдээлэл сонсож, холбогдох боловсруулсан журам, баримт бичигтэй танилцсан. Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын баталсан "Цахим аймаг" бодлогын зөвлөмжийн хэрэгжилтийг хангах, орон нутагт цахим шилжилтийг эрчимжүүлэхэд тулгамдаж буй асуудлуудад мэргэжил арга зүйн зөвлөн туслах үйлчилгээ үзүүлэх "Цахимд хэвшье" уриатай "Digital firstD1" арга хэмжээнд оролцсон. ХЭҮК-оос "Хүний эрхийн төлөө хамтдаа" нээлттэй өдөрлөгийг Булган аймагт зохион байгуулсан сургалтад бүх байцаагч нар хамрагдсан.Монгол Улсын хөгжлийн бодлого, төлөвлөлт ба байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний уялдаа төрийн албан хаагчийн мэргэшүүлэх сургалтад 1 байцаагч хамрагдаж амжилттай төгсөн сертификатаа авсан. | 100 |
| 4. | Төсвийн хөрөнгийн төлөвлөлт, зарцуулалтын ил тод байдлыг хангах .<br>а.Төсвийн гүйцэтгэлийн мэдээг сар бүр самбарт тавих<br>б.Шилэн дансны мэдээллийг цахим болон цаасаар ил тод болгох | Шилэн дансны тухай" хууль болон Ил тод байдлыг дагаж мөрдөх журмыг хэрэгжүүлэх тухай Монгол улсын Засгийн газрын 2011 оны 17-р тогтоолыг мөрдөж ажиллах. | 2024 онд орон нутгийн төсвөөс 642,609.7 сая төгрөгийн санхүүжилтийг авч, хуваарийн дагуу зардлын эдийн засгийн ангилал тус бүрээр зарцуулсан байна. Нийт төсвийн 85.1 хувийг цалин хөлс, нийгмийн даатгалын шимтгэлд хууль, тогтоол, тушаал шийдвэр, байгууллагын дотоод журмын холбогдох заалтуудад нийцүүлэн байгууллагын даргын тушаал шийдвэрээр зарцууллаа.<br>Төсвийн нээлттэй ил тод байдлыг ханган Төсвийн тухай хууль, Шилэн дансны тухай хуулийн дагуу төсвийн төлөвлөлт, гүйцэтгэлийн мэдээ тайланг сар улирлаар нь гарган холбогдох газруудад хуулийн хугацаанд цахим болон цаасан хэлбэрээр хүргүүлж, байгууллагын мэдээллийн самбарт төсвийн гүйцэтгэлийн сар бүрийн мэдээ, төсвийн төлөвлөгөөг гүйцэтгэлтэй харьцуулсан харьцуулалтаар гарган байршуулж мэдээллийн ил тод нээлттэй байдлыг ханган ажиллаж хэвшсэн. Байгууллагын өмч хамгаалах байнгын зөвлөлийн үйл ажиллагааг тогтмолжуулж өмч хөрөнгийн ашиглалт, хадгалалт хамгаалалтад хяналт тавих ажлыг сайжруулж үндсэн хөрөнгө болон бараа материалын иж бүрэн бүртгэл тооллогыг хийн бүртгэлд байгаа тоног төхөөрөмжийн хадгалалт хамгаалалтад байнгын хяналт тавьж хэвшсэн байна.<br>Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журмын 8 дугаар хэсгийн 8.5-д "Төсвийн ерөнхийлөн захирагч (дотоод аудитын алба) нь Шилэн дансны тухай хуулийн 8.2-т заасны дагуу шилэн дансны үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллана" гэж тус тус заасны дагуу шилэн дансны тайлан илгээлт, мэдээлэл байршуулалтанд дотоод аудит хийж шилэн дансны тайланг цахим болон цаасаар тайлагнаж хэвшсэн. | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| **5.** | Олон нийтийн сүлжээнд албан ёсны цахим хуудсыг нээн ажиллуулах, орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгслүүдтэй хамтран ажиллана. | Иргэд олон нийт тус албаны үйл ажиллагаа үнэн зөв явагдаж байгаа талаарх мэдээллийг тухай бүр авсан байна. | Албаны веб хуудсыг шинэчлэн хийгдсэн дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалтын чиглэлээр мэдээллийг улирал бүр байршуулсан. Тайлант онд дотоод аудитын хорооны хурлыг 2 удаа хийсэн. Аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт дотоод аудитын албаны төлөвлөгөөг батлах, төсвийн Ерөнхийлөн захирагчийн эрхлэх асуудлын хүрээнд явуулсан дотоод аудитын тайлан хэлэлцэн шийдвэрлэх, дотоод аудитын нэгжийн үйл ажиллагаанд зөвлөгөө өгөх, дэмжлэг үзүүлэх үүрэг бүхий “Дотоод аудитын хороо”-нд өөрчлөлт оруулах тогтоолын төслийг батлуулсан. Сангийн яамнаас ирүүлсэн 2024 оны 8 сарын 27-ны өдрийн СХШХ/07 тоот нэгдсэн удирдамжийн дагуу Булган аймгийн Татварын газрын 2022-2023 оны санхүү, төсвийн гүйцэтгэл болон үйл ажиллагаанд хяналт шалгалт хийсэн дүнг дотоод аудитын хорооны хурлаар хэлэлцүүлсэн. | |
| **Хэрэгжилтийн дундаж хувь** | | | | **100** |

***Хэрэглэгчийн үнэлгээний тайлан***

Байгууллагын үйл ажиллагааг үнэлж дүгнэх, улмаар хяналт шалгалтын үйл ажиллагааг сайжруулах зорилгоор үнэлгээ авахад дараах байдалтай байна.






## ДӨРӨВ. ДҮГНЭЛТ

Санхүүгийн хяналт дотоод аудитын албаны үйл ажиллагаа нь хуулийн хүрээнд ил тод нээлттэй байдлаар явагдаж, албан хаагчдын мэргэжлийн ур чадвар, зөвлөгөө өгөх байдал, санхүүгийн хяналт шалгалтын үр дүн хангалттай, харилцаа хандлага сайн байгааг илэрхийлж байгаа боловч мэдээ мэдээллийн хүртээмжийг нэмэгдүүлэх, байгууллагын вэб сайтыг өргөжүүлэх, хэрэглэгчдийн сэтгэл ханамжийн судалгааны асуумжыг тогтмол авч судалгааг үр дүнтэй болгоход анхаарч ажиллах шаардлагатай байна. Байгууллагад хамааралтай арга хэмжээг төлөвлөгөөнд тусгаж өгсөн нь хэрэгжилтэд эерэг үр дүн үзүүлж байна.

## ТАВ. ЗӨВЛӨМЖ

Төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээний тайланг тайланд тавигдах шаардлагад нийцүүлэн үнэн бодитой, иж бүрэн нотолгоотойгоор цаг хугацаанд нь тайлагнахыг ажилтнуудад зөвлөж байна. Цаашид байгууллагын үйл ажиллагааг эрчимжүүлэх, байцаагч нарын хэвийн үйл ажиллагааг хангаж ая тухтай, аюулгүй, ээлтэй орчныг бүрдүүлэх, ажлын онцлог шаардлагад нийцүүлэн өрөөний тоог нэмэгдүүлэх шаардлагатай байна.

ХЯНАСАН:

ДАРГА Б.БАТТУЛГА

ТАЙЛАГНАСАН:

САНХҮҮГИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН УЛСЫН

АХЛАХ БАЙЦААГЧ А.АНХБАЯР

САНХҮҮГИЙН ХЯНАЛТ ДОТООД АУДИТЫН АЛБАНЫ ЖИЛИЙН 2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮНЭЛГЭЭНИЙ ДҮН

| үзүүлэлт | | хувь | жин | оноо |
|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 | 5 |
| Бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн үнэлгээ | 1. Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт | 100 | 0.6 | 1,5 |
| | 2. Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт | 100 | | 1,5 |
| Байгууллагын чиг үүргийн үзүүлэлтийн үнэлгээ | 1. Байгууллагын тухайн жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт | 98.3 | 0.2 | 0,49 |
| | 2. Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн биелэлт | 100 | | 0,5 |
| Байгууллагын нээлттэй байдлын үнэлгээ | 1. Байгууллагын ил тод байдлын үнэлгээ | 100 | 0.2 | 0,25 |
| | 2. Шилэн дансны хөтлөлтийн үнэлгээ | 98.7 | | 0,24 |
| | 3. Шударга байдлын түвшний үнэлгээ | 100 | | 0,25 |
| | 4. Хэрэглэгчийн үнэлгээ | 95.5 | | 0,23 |
| Ерөнхий үнэлгээ | | 99,0 | 1 | 4,96 |

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН 2020-2024 ОНД
ХЭРЭГЖҮҮЛЭХ “ШИНЭ ХӨГЖЛИЙН ЗАМ” ХӨТӨЛБӨРӨӨС
САНХҮҮГИЙН ХЯНАЛТ ДОТООД АУДИТЫН АЛБАНД ХАМААРАЛТАЙ АРГА ХЭМЖЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТ

Хавсралт-1

| № | Зорилт | Хэрэгжүүлэх арга хэмжээ | Хүрсэн түвшин буюу гүйцэтгэлийн хувь (хүрээгүй бол шалтгаан, нөхцөл тайлбар |
|---|---|---|---|
| Аймгийн Засаг даргын 2020-2024 онд хэрэгжүүлэх “Шинэ хөгжлийн зам” хөтөлбөрөөс хамаарах заалт | | | |
| 1 | Зорилт 1.4.1: Анхдагч түмний бахархал, монгол өв соёлыг хойч үедээ өвлүүлэх, орчин үеийн соёл урлагийг түгээн дэлгэрүүлэх замаар соёл урлагийн тогтвортой хөгжлийг хангана. | Арга хэмжээ 1.4.1.1: монгол хэл, бичгээ дээдлэх, бүх нийтийн хэрэглээ болгох ажлыг ЕБС-иуд, мэргэжлийн байгууллагуудыг түшиглэн зохион байгуулах | Монгол бичгийн үндэсний хөтөлбөр -III -ийг хэрэгжүүлэх зорилтын хүрээнд шинэчилсэн стандартыг судлан үндэсний бичгээр өөрийн байгууллагад хэрэглэгдэж байгаа улсын ахлах байцаагчийн акт, албан шаардлага, танилцуулга, удирдамжийн бичвэрийг боловсруулах туршилт хийж эхлээд байна. Мөн байгууллагын хаягийг уйгуржин болон кириллээр бичсэн. Албан хаагчдын монгол хэл, үндэсний бичгийн мэдлэг чадварыг дээшлүүлэх арга хэмжээ авах, сургалтын хөтөлбөрийг байцаагч нарын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд оруулж өгсөн.Төрийн албан хаагчийн үндэсний бичгийн мэдлэгийг тодорхойлох судалгаанд бүрэн хамрагдсан.<br><br>Гүйцэтгэлийн хувь 90 |
| 2 | Зорилт 1.5.1 Аймгийн хөдөлмөрийн зах зээлийн судалгааг үндэслэн орон нутгийн хэрэгцээ шаардлагад нийцсэн хүн амын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих дэд хөтөлбөр хэрэгжүүлж, төр хувийн хэвшлийн хамтын ажиллагааг бэхжүүлнэ. | Арга хэмжээ 1.5.1.3: Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн чиглэлээр байгууллага, аж ахуйн нэгжүүдтэй хамтран ажиллаж “Бүтээмжийн хөдөлгөөн” өрнүүлэх шинэ санал санаачилгыг дэмжих | 2024 онд хяналт шалгалтаар ажиллах албан үүргээ гүйцэтгэх, албан томилолтоор ажиллах хугацаанд согтууруулах ундааны зүйл хэрэглэхгүй, ажлын байранд албаны бус хувцаслахгүй, бүдүүлэг үг хэллэг хэрэглэхгүй, зан авир гаргахгүй, ажил хэрэгч, ёс зүйтэй хариуцлагатай, бусдыг үлгэрлэх, манлайлах, албан тушаалын тодорхойлолтод заасан чиг үүрэг, бүрэн эрхээ хэрэгжүүлэх боломж нөхцөлийг бүрдүүлж, бүх талын дэмжлэг туслалцаа үзүүлж, мэргэжил арга зүйн удирдлагаар тухай бүр хангаж ажилласан.<br><br>Гүйцэтгэлийн хувь 100 |
| 3 | Зорилт 2.1.3: Төрийн худалдан авах ажиллагаагаар дамжуулан дотоодын үйлдвэрлэлийн бүтээгдэхүүний худалдан авалтыг дэмжинэ | Арга хэмжээ: 2.1.3.1 орон нутгийн үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээ эрхлэлтийг дотоодын худалдан авалтыг дэмжих | Батлагдсан төсвийн хүрээнд орон нутгийн Шунхлай петролиум ХХК-иас 6,600.0 мянган төгрөгийн шатахуун, бичиг хэргийн материалд 2,390.0 мянган төгрөгийг, шуудан холбооны интернэтийн зардалд 1,287.8 мянган төгрөгийг албан хаагчдын техник хэрэгслийг сайжруулахад суурин компьютер, 3 ширхгийг худалдан авахад 11,400.0 мянган төгрөгийг тус тус зарцуулсан. Статистикийн хэлтэст сар бүр мэдээг өгсөн.<br>Зардалтай холбоотой мэдээллийг shilendans.gov.mn-д мэдээллийг сар бүр шивж байна<br><br>Гүйцэтгэлийн хувь 100 |
| 4 | Зорилт 2.1.5 : Төсөв санхүүгийн цахим систем нэвтрүүлж, төрийн үйлчилгээг шуурхай, үр ашигтай болгож, төсвийн зардлын ил тод байдлыг хангана | Арга хэмжээ 2.1.5.1 : Төсөв санхүүгийн цахим системийг үе шаттай нэвтрүүлэх | Хүний нөөцийн программаас цалингийн холбогдох мэдээллийг татан ТАЦНС-ээр бодож олгож байна. Энэ оны 12 сарын 18-ны байдлаар 261,311.0 мянган төгрөгийн цалин, 30,569.5 мянган төгрөгийн НДШ-ийн тооцоог ТАЦНС-ээр тооцож тайлагнасан байна. Ажилтнууд тоон гарын үсгээ бүрэн авсан.<br><br>Гүйцэтгэлийн хувь 100 |
| | | Арга хэмжээ-2.1.5.2 : Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хангах | Байгууллагын шилэн дансны тухай хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ заасны дагуу шилэн дансны нэгдсэн сайтад 147 мэдээлэл оруулахаас 147 мэдээллийг хугацаа хоцроолгүй бүрэн мэдээлж, тайланг байгууллагын админ эрхээр илгээсэн.<br>Аймгийн хэмжээнд шилэн дансны хуулийн хэрэгжилт 2024 оны 3 дугаар улирлын байдлаар 98,7 хувь, тайлан илгээлт 100 хувьтай байна. Шилэн дансны тухай хуулийн 8.2-т заасны дагуу Санхүүгийн хяналт дотоод аудитын албанаас хийсэн хяналт шалгалтаар 2024 оны 3 дугаар |

| | | | |
|---|---|---|---|
| | | | улиралд шилэн дансанд 23947 мэдээлэл мэдээлэхээс 23638 мэдээллийг хугацаанд нь мэдээллэж 108 байгууллага 309 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.<br><br>Гүйцэтгэлийн хувь 90 |
| 5 | Зорилт 2.1.6 : Аж ахуйн нэгж байгууллагын бүртгэл хөтлөлт, олон улсын стандарт нэвтрэлтийг сайжруулах замаар төсвийн орлогын бүрдүүлэлт, төсвийн зарцуулалтынүр ашгийг дээшлүүлж, удирдлагын бүх шатанд төсөв, санхүү нягтлан бодох бүртгэлийн оновчтой шийдвэр гаргаж хэрэгжүүлнэ. | Арга хэмжээ-2.1.6.1: Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, бүртгэлийн олон улсын стандарт, холбогдох заавар журмын хэрэгжилтийг хангах | Төсвийн тухай хуулийн 16.5.5.батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах заалтын дагуу 364,625.2 мянган төгрөгийг зарцуулж, өглөг, авлагагүй ажилласан. Санхүүгийн тайлан, хувь хүний орлогын албан татварын тайлан, нийгмийн даатгалын шимтгэлийн тайланг хуулийн хугацаанд бүрэн гаргасан.<br><br>Гүйцэтгэлийн хувь 100 |
| | | Арга хэмжээ -2.1.6.2: Төсвийн гүйцэтгэлд дүн шинжилгээ хийж зөвлөмж гаргах, эрсдэлийн удирдлагаар хангах | Өнгөрсөн онд хийсэн хяналт шалгалтын дүнд цаашид анхаарах асуудлаар зөвлөмж боловсруулан сум албан байгууллагуудад хүргүүлсэн. Шилэн дансны нэгдсэн сайтад мэдээлсэн байдлыг аймгийн ИТХ-ын хуралдаанд мэдээлж, хуралдааны тогтоол гаргуулсан.<br><br>Гүйцэтгэлийн хувь 100 |
| 6 | Зорилт 4.1.1: “Цахим Монгол” төрийн үйлчилгээг орон нутагт үр дүнтэй хэрэгжүүлнэ. | Арга хэмжээ 4.1.1.1: Тоон гарын үсгийг хэрэглээнд нэвтрүүлэх ажлыг эрчимжүүлэх | Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 7.1.Суутган төлөгч энэ хуулийн 14 дүгээр зүйл, 16.1.2, 16.1.3, 16.1.4, 17.1.1, 18 дугаар зүйл, 19.1.1, 19.1.2, 20.1-д заасны дагуу тодорхойлсон орлогод ногдуулан суутгасан албан татварын улирлын тайланг дараа улирлын эхний сарын 20-ны өдрийн дотор, жилийн тайланг дараа оны 02 дугаар сарын 15-ны өдрийн дотор өссөн дүнгээр гаргаж, харьяа татварын албанд хүргүүлнэ заалтын дагуу хувь хүний орлогын албан татварын тайланг 3 удаа, Нийгмийн даатгалын тухай хуулийн 15.1, 16.3-д заасны дагуу ажил олгогч, даатгуулагчийн нийгмийн даатгалын шимтгэлийн тайланг тус тус цахимаар илгээсэн.<br><br>Гүйцэтгэлийн хувь 100 |
| 7 | Зорилт 4.1.2 Төрийн байгууллагын үйл ажиллагааны ил тод байдлыг нэмэгдүүлж, иргэд олон нийтийн оролцоог хангана. | Арга хэмжээ 4.1.2.1 Аймаг сумдын ЗДТГ, аймгийн Засаг даргын дэргэдэх агентлаг, байгууллагуудыг цахим хуудастай болгох, шинэчлэх, үйл ажиллагааг жигдрүүлэх | Sankhuuhyanalt.bu.gov.mn вэб сайт танилцуулга, мэдээ мэдээлэл, ил тод байдал, эрх зүйн акт, шилэн данс гэсэн цэсүүд ажиллуулж байна. Sankhuu audit bulgan нүүр номоо шинэчилсэн.<br>Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулинд заасны дагуу байгууллагын эрхлэх асуудлын хүрээнд хамаарах нээлттэй мэдээллийг Snilen.gov.mn шилэн ажиллаганы нэгдсэн системд мэдээлж 92 хувьтай үнэлэгдсэн.<br><br>Гүйцэтгэлийн хувь 90 |
| 8 | Зорилт 4.2.2: Төрийн албаны хүний нөөцийг үе шаттай сургаж, мэргэшүүлэн төрийн албан хаагчдын ажиллах нөхцөл боломжийг сайжруулж, төрийн үйлчилгээний үр дүн, үр нөлөөг дээшлүүлнэ. | Арга хэмжээ 4.2.2.1: Төрийн жинхэнэ албан хаагч сонгуулийн үр дүнгээс үл хамааран чадахуйн болон шатлан дэвших зарчмын дагуу төрийн албанд тогтвортой ажиллах нөхцөлийг бодитоор хэрэгжүүлэх | Байгууллагын нийгмийн баталгааны хөтөлбөрийн хүрээнд ажилтнуудад өдрийн 5.0 мянган төгрөгөөр тооцон 8 албан хаагчид нийт 6,998.9 мянган төгрөгийн хоолны хөнгөлөлт, галлагаатай байшинд амьдардаг 4 албан хаагчид тус 300,0 мянган төгрөг нийт 1200,0 мянган төгрөгийн түлээ нүүрсний хөнгөлөлтийг олгосон.<br><br>Гүйцэтгэлийн хувь 100 |
| | | Арга хэмжээ 4.2.2.2: Төрийн албанд шинээр томилогдсон иргэнийг орон нутаг, төрийн албаны анхан шатны нэгжид ажиллуулан, дадлагажуулах замаар мэдлэг чадвар, туршлагыг нэмэгдүүлэх | Байгууллагын сургалтын хөтөлбөрийн хүрээнд ажлын байранд шинээр ажилд орсон, залуу ажилтнуудыг дадлагажуулж байна. Тайлант Булган аймаг дахь Төрийн албаны зөвлөлөөс зохион байгуулсан “Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль” сэдэвт танхимын сургалтад хамрагдсан. Орхон аймагт зохион байгуулсан дотоод аудитын удирдлагын нэгдсэн системд хэрхэн ажиллах талаарх сургалтад хамрагдахын зэрэгцээ тус аймгийн Санхүүгийн хяналт дотоод аудитын албаны нэвтрүүлсэн “Нэгдсэн менежмент тогтолцооны стандарт нэвтрүүлсэн сайн туршлага”-ын талаар мэдээлэл сонсож, холбогдох боловсруулсан журам, баримт бичигтэй танилцсан. Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын баталсан “Цахим аймаг” бодлогын зөвлөмжийн хэрэгжилтийг хангах, орон нутагт цахим шилжилтийг эрчимжүүлэхэд тулгамдаж буй асуудлуудад мэргэжил арга зүйн |

| | | | |
|---|---|---|---|
| | | | зөвлөн туслах үйлчилгээ үзүүлэх “Цахимд хэвшье” уриатай “Digital firstD1” арга хэмжээнд оролцсон. ХЭҮК-оос "Хүний эрхийн төлөө хамтдаа" нээлттэй өдөрлөгийг Булган аймагт зохион байгуулсан сургалт, Орхон аймагт зохион байгуулсан “Нэгдсэн менежментийн тогтолцооны стандартуудыг нэвтрүүлсэн туршлага, дотоод аудитын удирдлагын мэдээллийн системийн ашиглалтыг сайжруулах” сургалт, Монгол улсын дотоод аудиторуудын форум сургалтад албан хаагчдийг хамруулсан.<br><br>Гүйцэтгэлийн хувь 100 |
| | | Арга хэмжээ 4.2.2.3: Төрийн албанд иргэнийг авах, албан тушаал дэвшүүлэх, чөлөөлөх, шилжүүлэх, сэлгэн ажиллуулах, түр томилох, сургаж хөгжүүлэх бодлого зохицуулалтыг чадахуйн зарчимд нийцүүлэх | Төрийн бодлогын залгамж чанарыг хадгалах, тогтвор суурьшилтай ажиллуулж, төрийн мэргэшсэн албыг бэхжүүлэх зорилгоор Төрийн албаны тухай хууль, хуулийг дагалдан гарсан дүрэм, журмын дагуу одоо ажиллаж байгаа албан хаагчдын мэдлэг чадварыг дээшлүүлэх, сул орон тоо гарсан үед нөөцөд байгаа төрийн албан хаагчдаас нөхөх бодлого, чиглэлийг баримтлан ажиллаж байна. Тайлант онд 1 сул орон тоо гарсаныг Төрийн албаны тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 1 дэх заалт болон Төрийн албаны зөвлөлийн 2023 оны 25 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн албаны шалгалт өгөх болзол болон шатлан дэвшүүлэх, сонгон шалгаруулах журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.2-т заалтуудыг үндэслэн төрийн албан хаагчийн өөрийн нь гаргасан өргөдлийн дагуу Нийгмийн даатгалын хэлтсээс шилжүүлэн авсан.<br><br>Гүйцэтгэлийн хувь 100 |
